# ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН МЭДЭЭ

2022 оны 12 дугаар сарын 05

| Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтийн мэдээ |
|---|---|---|
| ЗГ-ын хуралдааны тэмдэглэл<br>2022-11-22<br>Дугаар 2022_20 | 1.”Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнүүдийг эрчимжүүлж ажиллах, удаашралтай хэрэгжиж байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг 2022 оны зорилтод түвшинд хүргэхийг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдлагуудад; | “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө” болон “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилт нь удаашралтай байгаа заалтуудыг эрчимжүүлэх ажлын хүрээнд сар бүр төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангач ажиллаж байна. 2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 73,3%, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийн дундаж 72,5 хувьтай хэрэгжиж байна. |
| | 2.”Удаашралтай хэрэгжиж байгаа арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2023 оны Улс, Нийслэлийн төсөвт тусгуулан хэрэгжилтийг хангах ажиллахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газар (И.Баатархүү)-т Нийслэлийн нутгын захиргааны байгууллагуудын удирдлагуудад тус тус үүрэг болгов” гэжээ. | Нийслэлийн нийтийн тээврийн газрын нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх авто замын түгжрэлийг бууруулах төсөл, арга хэмжээний жагсаалт, мөн нийслэлийн нийтийн тээврийн газрын нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2021-2022 онд он дамжуулан хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалтын ажлын жагсаалт болон ажлын явцын талаарх мэдээллийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн 1/1419 дугаартай албан бичгээр хүргүүлсэн. Нийслэлийн Засаг даргын Тамгын газар “Моннис моторс” ХХК хооронд 2020 оны 07 дугаар сарын 02-ны өдөр байгуулагдсан НЗДТГ-20/А-463-2 дугаар “Нийтийн тээврийн шинэ шийдэл төсөл, парк шинэчлэлт, хүүхдийн сургуулийн автобусны төслийн хүрээнд хүүхдийн сургуулийн автобус худалдан авах гэрээ”-нд тус газар нь Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/463 дугаар захирамжийн дагуу захиалагчийн хяналт хэрэгжүүлэн ажиллаж байгаа. Моннис моторс ХХК-иас 2022 оны 12 дугаар сарын 20-ны дотор үлдэгдэл 50 ширхэг хүүхдийн сургуулийн автобусыг бүрэн нийлүүлж дуусахаар төлөвлөөд байгаа талаар тус газарт 2022 |

| | | |
|---|---|---|
| | | оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 01/736 дугаартай албан бичгээр хүсэлтээ ирүүлээд байна. |

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ХЭЛТСИЙН ДАРГА З.ЦЭВЭЭНДОРЖ

НЭГТГЭСЭН:
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.БОЛОРЦЭЦЭГ